

## **“РАДИО ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2014 ОНЫ ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2014-12-17

Улаанбаатар хот

Манай байгууллага нь 2014 онд Төрийн өмнөөс гүйцэтгэх ажлын хүрээнд Радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээгээр МР-ийн 1-р программыг ДСВ-75-500 нэвтрүүлэгчээр 164-882 кГц-ийн урт долгионоор болон FM станцаар 265373,341 цаг, МР-ийн 2-р программыг NEC-10-50 нэвтрүүлэгчээр 7260, 4830, 4895 кГц-ийн богино долгионоор 32372,47 цаг, 3-р программыг FM-109 долгионоор 5839,7 цаг, МТН-ийн программыг ПКВ-250 нэвтрүүлэгчээр 12085, 12015 кГц-ийн богино долгионоор 1455,33 цаг тус тус дамжууллаа.

Телевизийн дамжуулах сүлжээгээр МҮОНТ нэвтрүүлгийг 2,6-р сувгаар тус бүр 2302452,17 цаг, телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг 50 Вт-ын станцаар 2068249,13 цаг, 100 Вт-аар 55623,04 цаг, 200 Вт-аар 135324,14 цаг, 500 Вт-аар 43255,86 цаг тус тус дамжуулсан байна.

Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

**Нэг. “Радио, телевизийн сүлжээний газрын техник технологийг  
2017 он хүртэл хөгжүүлэх чиглэл”-ийг хэрэгжүүлэх  
хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлууд**

### **Удирдлага зохион байгуулалт, технологийн шинэчлэлийн үйл ажиллагааны талаар**

Байгууллагын хэмжээнд 2014 онд Техник зохион байгуулалтын арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж сар бүрээр төлөвлөн, тайланг нэгтгэн биелэлтэнд нь хяналт тавин ажиллалаа. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийн шуурхайг өглөө бүр, байгууллагын чанарын зөвөлгөөнийг 7 хоног тутам хийж ажлын явцыг хэлэлцэн, холбогдох арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлэн тухай бүр хурлын тэмдэглэл хөтлөн ажиллалаа.

**“Радио, телевизийн сүлжээний газрын техник технологийг 2017 он хүртэл хөгжүүлэх чиглэл”-ийг боловсруулан чиглэлийг хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлж эхлээд байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, чиг үүргийн хүрээнд дараах чиглэлүүдээр ажиллалаа.**

#### **1. Шинэ техник технологийн талаар:**

Хөтөлбөрт тусгагдсан төлөвлөгөөний дагуу хөгжлийн чиглэлийн суурь төсөл болох **“Интернэт радиог хөгжүүлэх”** “Радио нэвтрүүлэх станцуудын дамжуулах системийг шинэчлэх” “Интернэт радио, дамжуулах системийн тоног төхөөрөмжийн тэжээлийн найдвартай байдлыг хангах” төслүүдийг боловсруулж батлуулан, гүйцэтгэгч компанийг сонгох ажлыг зохион байгуулж шалгарууллаа.

Энэхүү төслүүдийг **Улаанбаатар хот, Өмнөговь, Говь-Алтай, Баян-Өлгий, Хөвсгөл, Дорнод аймгуудад** харьцангуй богино 3,5 сарын хугацаанд шуурхай хэрэгжүүлж хүлээлгэн өгөөд байна.

Интернэт радиог хөгжүүлэх төслөөр МҮОНР-ийн нэгдүгээр програмыг интернэт орчинд монгол улсын болон гадаадад суугаа иргэд сонсох боломжтой болох, хэрэглэгч нь интернэт бүхий орчинд ухаалаг гар утас, таблетууд, утастай болон утасгүй интернэт хүлээн авагч, компьютерийн програм зэрэг дурын хэрэглэгчийн төхөөрөмжөөр сонсох боломжийг бүрдүүллээ.

Төсөлд тусгасны дагуу **вeб, тоглуулагч, статистикийн програм хангамжуудыг** хийлгэж, хэрэглэгчийн тоглуулагчийн програм дээр байгууллагын Logo байрлуулах дүрст сурталчилгааг өөрчлөн хэрэглэгчийн төхөөрөмжид дүрс хэлбэрээр явуулах боломжтой боллоо. Интернэт серверт холбогдож байгаа хэрэглэгчийн тоо, минут хугацааны статистик мэдээллийг гаргах боломжтойгоор хийгдсэн нь холбогдсон хэрэглэгчийн тоог гаргах интернэт ачааллыг хянаж тохируулах боломжтой болгосон юм.

Монгол улсад одоогоор хэрэгжээгүй байгаа **утастай болон WiFi интернэт хүлээн авагчаар радио нэвтрүүлэг хүлээн авдаг болох**, хэрэглэгчийг хангах зорилгоор **Гонг Конг-ийн Хипшин компанид Интернэт радио** серверийн өгөгдлүүдийг өгч, хүлээн авагчид суулгуулан туршилтын **2 ширхэг WiFi болон LAN** холболттой хүлээн авагчийг захиалан үйлдвэрлүүлээд байна.

Хүлээн авагчийг турших ажил амжилттай болж, цаашдаа хямд үнэтэй хүлээн авагч үйлдвэрлүүлэн **интернэт хүлээн авагчийг** Улаанбаатар хотод шугамын радиог орлуулах, WiFi сүлжээ бүхий сумуудад нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Интернэт радиогийн ажиллагааг **Япон, АНУ, Хятад, Гонг Конг улсуудад** оршин суугаа иргэдэд сонсгож туршиж үзэхэд сонсгол сайн тасалдалгүй байлаа. Байгууллагын сүлжээнд гадаад **IP авах талаар Юнивишн** компанитай ажиллаж гадаад хаяг гаргуулж авлаа. Миком компаниас мөн интернэт радиогийн Domain нэр авч бэлэн болгоод байна. Гадаад хаяг Domain нэр авснаар сервер үүсгэж интернэт радио явуулах, түүнийг гадаадын улс орнуудаас сонсох боломж бүрдэж байгаа юм.

Интернэт радиог сонсдог **байнгын хэрэглэгч 630 болсон нь** статистикийн программаас харагдаж байна.

“Радио нэвтрүүлэх станцуудын дамжуулах системийг шинэчлэх” төслөөр физик кабелиас өөр дамжуулах системгүй байсан кабель шугам нь тасарсан, чанар муудсан Өмнөговь, Говь-Алтай, Баян-Өлгий, Хөвсгөл, Дорнод аймгуудын Холбооны газраас Радио нэвтрүүлэх станц хүртлэх **дамжуулах системийг 150Mbps интернэт урсгал дамжуулах боломжтой тоон радио линк болох Rокет5М** бридже суурилуулж, аймгуудын станцын интернэт хурдыг **800Kbps** болгож нэмэгдүүлээ. Баян-Өлгий аймгаас бусад физик кабель муу, кабель тасарсан кабельгүй аймгуудад **МЦХ ХК-ийн суурин утасны дугаарыг IP** телефоноор өгч байнгын холбоотой болголоо.

Орон нутгийн радио нэвтрүүлэх станцын дамжуулах системийг тоон систем болгон шинэчилснээр зөвхөн ДДиШ ХХК-ийн хиймэл дагуулаас радио програмыг хүлээн авдаг боловч их чадлын станцаар цацдаг, өөр нөөцгүй байсныг интернэт радиогоор нэвтрүүлэх станцын нөөц эх үүсвэртэй болголоо. Үүрэн холбооны 3G , интернэтийн WiFi сүлжээгээр болон гар утсаар интернэт радиог хүлээн авч, бүх сүлжээ доголдсон үед нэвтрүүлэх станцын радио эх үүсвэрийг хангах боломжтой болсон юм.

Энэ төслийн хүрээнд Улаанбаатар хотын Хонхорын нэвтрүүлэх станцын дамжуулах системд шинэчлэл хийж, олон компанийн байр, тоног төхөөрөмж, сүлжээг дамжиж өндөр түрээсийн төлбөр төлж байсан сүлжээг шинэчлэн төв байр, телевизийн төв станц, Чингэлтэй уулын сайт, Хонхорын нэвтрүүлэх станц гэсэн чиглэлээр, тоон радиогийн интернэт сүлжээг, Төв байр, Хонхорын нэвтрүүлэх станц гэсэн чиглэлээр шилэн кабелиар дамжуулан үүсгэлээ.

Чингэлтэй уулын сайт, Хонхорын нэвтрүүлэх станцын хооронд хайгуул хийж, линкийн тооцоог хийснээр 150Mbps урсгал дамжих боломжтой бридже сурилуулж, дамжуулах системийг шинээр байгууллаа. Энэ дамжуулах системээр Телевизийн төв станцаас МҮОНР-н нэг, хоёрдугаар болон тусгай нэвтрүүлгийг интернэтээр дамжуулж, Хонхорын станцад хүргэх 4 дууны encoder, хүлээн авах decoder-ийг суурилуулж ашиглаж байна.

Олон дамжлагатай шилэн кабелийн сүлжээг түрээсийн зардал багатай Sky Network компанийн шилэн кабелийн сүлжээнд шилжүүлэх хүсэлт тавьж, шилэн кабель татуулснаар E1 урсгал гаргуулан урд нь ашиглаж байсан encoder, PCM төхөөрөмжүүдийг ашиглан, шилэн кабелийн сүлжээг үүсгэх ажил хэрэгжиж байна. Энэ шинэчлэлийн үр дүнд Хонхорын нэвтрүүлэх станц нь 1Mbps интернэт хурдтай, Радиогийн 3 програм нь Интернэт, Сансарын, шилэн кабелийн гэсэн 3 нөөц радио эх үүсвэртэй боллоо. Мөн Юнивишин компанийн суурин телефоны 2 дугаарыг радио бридже сүлжээгээр хүргэлээ. Дамжуулах байгууламжийг шинэчлэх төслийг хэрэгжүүлсний үр дүнд гадны олон компанийн техникийн өрөө, тоног төхөөрөмж дамжиж түрээсийн төлбөр төлж, их зардал гаргадаг байсныг өөрчлөн бүх төхөөрөмжийг өөрийн төхөөрөмж болгон, шууд шилэн кабелийн холболттой болгосноор олон өрөө тасалгаа, олон тоног төхөөрөмжөөр дамжихгүй, бусад компаниас хамааралгүй өөрийн гэсэн дамжуулах сүлжээтэй боллоо.

Энэхүү төслүүдийн хүрээнд тоон телевизийг компьютер дээр хянах, компьютер дээр FM сувгуудыг хянах боломжтой болсноос гадна засвар үйлчилгээгээр явахдаа телевизор авч явахгүйгээр нэвтрүүлгээ хянах боломжтой авсаархан хувиргагчийг судалж, засварын ИТА-д, салбаруудыг хангаад байна.

“Интернэт радио, дамжуулах системийн тоног төхөөрөмжийн тэжээлийн найдвартай байдлыг хангах” төслийн хүрээнд судалгаа тооцоонд үндэслэн технологийн чанартай тоног төхөөрөмжүүдийг, UPS тэжээлийн үүсвэрээр хангаснаар аймаг орон нутаг, Улаанбаатар хотын станцуудын тэжээлийн найдвартай ажиллагааг хангалаа. Төслийг хэрэгжүүлсэн 9-р сараас хойш зай тэжээл, дамжуулах төхөөрөмж,

интернэт радиогийн гэмтэл саатал гараагүй байна. Харин ашиглалт, ИТА-ын мэдлэг, мэрэгжлийн ур чадвар муу, дадлага туршлагагүй байдалтай холбоотой саатал, доголдол 3 удаа гарсан байна.

Техникийн шийдэл, судалгааг ТАХ-ийн мэргэжилтэн нартай хамтран хийж, Юнивишн компанийн интернэт сүлжээнд тулгуурлан, ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн нөөц бололцоог оновчтой зохион байгуулснаар Улаанбаатар хотын төв байрнаас Телевизийн төв станц, Чингэлтэй уулын станц, Хонхорын станц, ХРША чиглэлд байгууллагын хувийн сүлжээ болох VPN сүлжээг ямар нэг зардал гаргалгүй шийдвэрлэлээ. Ийм сүлжээтэй болсны үр дүнд бүх салбарууд байгууллагын нэг сүлжээнд ажиллах бөгөөд салбаруудын тоног төхөөрөмжийг дурын салбараас хянах, тохируулах, хандаж шалгах боломжтой болсон юм.

Төслүүдийг хэрэгжүүлснээр зардал хэмнэж, бага үнээр чанартай үйлчилгээг авдаг боллоо. **Хонхорын станцын шугамаас жилд 7,2 сая төгрөг хэмнэж, орон нутгийн дамжуулах сүлжээг байгуулснаар дунджаар 50000 төгрөгийн төлбөрөөр 300Kbps интернэтийн урсгал авдаг байсан бол 800Kbps урсгалыг 68000 төгрөгөөр авдаг болж, интернэтийн нэгж kbps хурдад ноогдох зардлыг 2 дахин бууруулж, бага үнээр өндөр хурд авдаг болсон байна. Улаанбаатар хотод зөвхөн Хонхор чиглэлд шилэн кабелийн түрээс 1Mbps интернэт хурдыг жилд 15 орчим сая төгрөгөөр авдаг байсан бол одоо Улаанбаатар хотын бүх салбарт 5Mbps интернэт урсгалыг хуваан хүргэж, жилд 7,8 сая төгрөг төлдөг боллоо. Урсгал тав дахин нэмэгдэж, зардал 2 дахин буурсан байна.**

Газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж Радио дамжуулах сүлжээг шинэчлэх болон интернэт радиог хөгжүүлэх, зай тэжээлийн найдвартай ажиллагааг хангах төслийн хүрээнд суурилуулагдсан төхөөрөмжийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, акт баримтыг бүрдүүлэн холбогдох хэлтэс, албадад хүлээлгэн өглөө.

Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ITZONE ХХК-ийн хэрэгжүүлсэн төслийн суурилуулалтын ажлыг өөрийн ИТА-аар хийлгэж, тодорхой төлбөрийг байгууллагын дансанд оруулах талаар байгууллагын даргатай хамтран ITZONE компанитай удаа дараа уулзалт хийж, тохиролцоонд хүрснээр хамтран ажиллах гэрээ байгуулж, суурилуулалтын ажлыг хийлээ. Телевиз, радиогийн тархалтыг судлах талаар Өвөр Жанчивлан, Хоолтын даваанд хайгуулын ажлыг хийж, хамрах хүрээг тодорхойллоо.

Хот орчмын телевизийн дахин дамжуулах станцуудыг тоон технологид шилжүүлэх төслөөр Телевизийн төв станц, Чингэлтэй уулын станц, Телевизийн төв, Баянхошууны сайтийн хооронд шилэн кабелийн шөрмөсөөр холбох шаардлага гарсан тул Скайнэтворк, Ханском компанитай тохиролцож, шилэн кабель татуулан Чингэлтэй уулын станцыг холбоод байна.

Улаанбаатар хот орчмын тоон станцыг суурилуулах ажилд хяналт тавьж, 61-ийн гарам, Багахангайн тоног төхөөрөмжийг суурилуулах талаар Мобиком компанитай хамтран ажиллаж, зай талбай хүрэлцэхгүй түрээсийн төлбөр өндөр гарах байсан тул ашиглалтын шаардлага багатай UPS төхөөрөмжийг суурилуулахгүй байх

талаар гүйцэтгэгч Ньютел компанитай тохиролцон, гэрээг шинэчилж Мобикомын сайт дээр суурилуулалтын ажлыг эхлүүлээ.

“Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн DVB-T2 системийн хүлээн авах төхөөрөмжийг орон нутгийн айл өрхүүдэд борлуулж, хэрэглэгчийн тоог нэмснээр аналогийн станцыг зогсоож, ЭХ зардлыг хэмнэх зорилгоор DVB ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Хамтран ажиллах гэрээний дагуу айл өрхүүдэд төхөөрөмж борлуулах журмыг боловсруулан, Газрын даргын 2014 оны №276 тоот тушаалаар батлуулж, аймгийн станцын дарга нарт журмыг хүргүүлж, 800 хүлээн авагчийг хүргэх ажлыг зохион байгуулаад байна.

## **2. Бодлого, төлөвлөлт зохицуулалтын талаар:**

Тоон телевизийн дахин дамжуулах станцуудыг ашиглалтанд хүлээн авч үйлчилгээ үзүүлж эхэлсэнтэй холбогдуулан тоон телевизийн дахин дамжуулах станцуудаар нэвтрүүлэг дамжуулах тарифийг ХХЗХ-ны тариф боловсруулах аргачлалын дагуу боловсруулж, ХХЗХ-оор батлуулахаар 7 сард хүргүүлсэн боловч шийдвэрлэгдэхгүй байсаар хороогоор батлуулах боломжгүй гэдэг албан бус хариуг 12-р сарын 5-нд мэдэгдсэн. Цаашид хэрхэн хаана батлуулах талаар ажлын зөвлөлөөр хэлэлцүүлэхээр шийдвэрлээд байна. Тарифийг батлуулснаар дахин дамжуулах станцаас орох орлогыг оруулж зардлыг нөхөх юм.

МҮОНР-ийн нэгдүгээр програмыг Монгол улсын нутаг дэвсгэрт нэг давтамжаар дахин дамжуулж, хэрэглэгч сонсогчдын сонголтыг хийхэд хялбар болгох, РТС УТҮГ-ийн бренд давтамжийг 105,5МГц давтамж болгох саналыг дэвшүүлж хэрэгжүүлж эхлээд байна. ХХЗХ-той зөвшилцөж, 105,5МГц давтамжийг эзэмшин Монгол улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авах өрөгдлийг бүрдүүлж өгөөд байна.

Хоёр хөрш орны радио нэвтрүүлгийг Улаанбаатар хотод ФМ станцаар дахин дамжуулах болсонтой холбогдуулан 2 ширхэг ФМ давтамжийн зөвшөөрлийг авах талаар уулзаж тохиролцсоноор өргөдлийг боловсруулж, ХХЗХ-д хүргүүлээд байна. Нэвтрүүлгийг дамжуулснаар нэмэгдэл орлого орох боломжтой болох бөгөөд техникийн боломж, тоног төхөөрөмжийг судалж бэлтгээд байна.

Төрийн өмчийн хорооны шийдвэрээр шилжиж ирсэн **24 цамхгийг хүлээн авах**, цамхагт байрлуулсан антенн тоног төхөөрөмжийг бүртгэх ажлыг хийж, МХС ХХК-д мэдээлэл авах, хүлээлгэн өгөх талаар албан тоот, үүрэн холбооны оператор компаниудад гэрээг шинэчлэн хийх талаар албан тоотуудыг явуулж, тоног төхөөрөмжүүдийг тулгаж гэрээг шинэчилж байна. Агаарын баганын түрээсийн төлбөр зах зээлийн үнээс хэт доогуур мөрдөж байсныг шинэчлэн батлуулж мөрдсөн.

Байгууллагын веб хуудсанд үзүүлж байгаа үйлчилгээ, даргын мэндчилгээ, эрхэм зорилгыг шинэчлэн боловсруулж, дарга удирдлагатай зөвлөж байршууллаа. Веб сайтийн дизайнын өөрчлөлтийг дотоодын нөөц боломжоор хийж, өөрчилж чадахгүй байгаа тул цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон.

Веб хуудсанд байгууллагын үзүүлж байгаа үйлчилгээг хэрхэн авах ямар телефон болон мэйл хаягаар хүсэлт тавьж болохыг тодорхой тусгаж [service@rtbn.gov.mn](mailto:service@rtbn.gov.mn) хаягаар үйлчилгээний хүсэлтийг хүлээн авдаг, хариу өгдөг боллоо. Байгууллагын мэдээллийг хүлээн авах 18001806 тусгай дугаарыг МЦХ ХК-аар нээлгэн ашиглаж, зөвшөөрлийн гэрээг ХХЗХ-той хийн хураамжийг төлөөд байна.

Монгол Улсын төсөвт тусгах “Радио телевизийн сүлжээний газар”-аас 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, томоохон засварын зардлын төслийг боловсруулан МТШХХГ-тай урьдчилан тохирч баталгаажууллаа. Тоон дахин дамжуулах станцууд ашиглалтанд орж байгаатай холбогдон эрчим хүчний зардлын тооцоог гаргаж, нэмэгдэх ЭХ-ний зардлыг 2015 оны зардалд тусгуулахаар МТШХХГ-т хүргүүлээ. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал оруулсан Телевизийн төвийн цамхгийн өргөгч лифтийн ТЭЗҮ-ийг гаргаж сангийн яам, МТШХХГ-т хүргүүлсэн

БНҮҮС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж 2015 онд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөрөнгө оруулалтын саналыг тодорхой тайлбар, үндэслэлтэйгээр гаргаж МТШХХГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх талаар ажиллаж байна.

Мөн сар бүрийн статистик мэдээтэй болох, станц сайтуудын тухай мэдээллийн сантай болохоор зорилт тавин ажиллаж байна. Ингэснээр станцуудын мэдээлэл, станцын ашиглалтын түвшин, гэмтэл саатлын мэдээ, орлогын тухай мэдээллүүдийг нэгтгэн нэг баазтай болох ба тухайн сумын мэдээллийг цуглуулан нэгтгэсэн мэдээллийн сантай болох юм. Уг ажлын хүрээнд Статистик мэдээ гаргах загвар хүснэгтийг гаргаж, тоон үзүүлэлт бүхий статистик мэдээг цуглуулан нэгтгэж, мэдээллийн санг бүрдүүлэхээр судалгаа хийн ажиллаж байна.

### **3 . Гэрээ, зохион байгуулалтыг сайжруулах талаар:**

Байгууллагын мөрдөж байгаа гэрээний маягтыг шинэчлэн сайжруулж, төлбөрийн болон орлогын гэрээгээр ангилан гэрээний матрицыг гаргалаа.

Энэхүү матриц нь ямар компанид юуны учир хэдэн төгрөг төлдөг, ямар компаниас хэдэн төгрөг авдаг зэрэг мэдээллийг агуулсан, сортолж мэдээлэл гаргахад хялбар болж байна.

Гадны байгууллагын хүсэлтийг үндэслэн цамхаг, байр талбайгаа түрээслэхэд техникийн хэлтсээс техникийн нөхцөл гаргуулдаг, нөхцлийн дагуу гэрээ хийгдсэний дараа БТХ-ийн зөвшөөрлөөр тоног төхөөрөмжийг суурилуулдаг журамд шилжүүлж, техникийн нөхцлийн маягт, зөвшөөрлийн хуудсыг боловсруулж мөрдөж байна. Энэ журамд шилжсэнээр зөвшөөрөлгүй техникийн горим зөрчиж, суурилуулалт хийдэг байдал бүрэн арилсан. Манай цамхаг, байр талбайг түрээсээр ашигладаг Топика, Квико компаниудын гэрээнд тусгасан тоног төхөөрөмжийг бодит байдалтай тулгаж, шинэчилсэн тарифаар тооцож гэрээг хийлээ.

Хэлтэс, алба нэгжүүдийг үнэлэх, техникийн түвшин тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, тоон үзүүлэлтээр нэгжийг үнэлдэг болох саналыг ДХХХХ-т тавьж техникийн түвшинг шалгах шалгуур үзүүлэлтийг тус хэлтэстэй хамтран боловсрууллаа.

**Албан байгууллагууд орон нутаг дахь Олон сувгийн телевизийн сайтын байр, цамхагт антенн, тоног төхөөрөмжөө байршуулах, мөн радиогийн зогсуурыг ашиглах хүсэлт гаргасны үндсэн дээр 7 ширхэг “Байр талбайн түрээсийн гэрээ”, 5 ширхэг “Зогсуур түрээсийн гэрээ”-г тус тус шинээр хийж, жилд 451,633,800 төгрөгийн орлого олох боллоо.**

**Харилцагч байгууллагын гэрээний хугацааг батлагдсан тарифын дагуу тооцож, нийт 12 гэрээ хийснээр орлого жилд 15,929,000 төгрөгөөр нэмэгдсэн.**

Мөн орон нутгийн телевизүүд тухайн аймаг, сумандаа телевизийн нэвтрүүлгээ дахин дамжуулах хүсэлт тавьсны үндсэн дээр Архангай, Хэнтий, Дорнод аймгуудын 4 телевизтэй гэрээ хийж, орон нутагт дахин дамжуулах бэлтгэлийг хийж эхлээд байна. Нэвтрүүлгийг дамжуулснаар жилд **7,3 сая** төгрөгийн орлого орох боломжтой болно.

Байгууллагын удирдлагаас шаардлагатай гэж үзсэн асуудлаар хувь хүн болон хуулийн этгээдтэй нийт 35 “Ажил гүйцэтгэх гэрээ”, 19 “Оператор ажиллагааны гэрээ”, 5 “Худалдах, Худалдан авах гэрээ”-г тус тус шинээр хийлээ.

**Хоёр. МУ-ын Засгийн 2014 оны 5-р сарын 147 дугаар “ Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор хийсэн ажлууд**

**Хүний нөөцийг хөгжүүлэх, орон тоо зохион байгуулалт, сургалтын талаар**

**1.Орон тоо зохион байгуулалтын талаар:**

**МУ-ын Засгийн 2014 оны 5-р сарын 147 дугаар “ Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, орон тоог цөөрүүлэх, зардал хэмнэх, орлого нэмэгдүүлэх тухай” Газрын даргын 2014 оны 6-р сарын 149 дугаар тушаалыг хэрэгжүүлэн дараахи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:**

1. Байгууллагын дэд даргын 1 орон тоог цомхотгосон.
2. УБ хотын гэр хороололын радио шугам татан буугдсантай холбогдуудлан Хотын шугамын радиогийн албанд 2 инженер, 5 засварчны орон тоог цомхотгосон .
3. Дорноговь аймгийн Радио нэврүүлэх станцад 1 техникч, 2 гэрээт ажилтаны орон тоог цөөрүүлсэн.

4. Байгууллагын хэрэгцээ шаардлагыг үндэслэн Эрх зүй хамтын ажиллагааны албыг татан буулгаж орон тоог нэмэхгүйгээр Бодлого төлөвлөлтийн хэлтсийг шинээр байгуулсан.

5. Эрх зүйн мэргэжилтний орон тоон дээр Хуулийн зөвлөхийг ажиллуулсан.

## **2. Сургалтын талаар:**

Тайлант хугацаанд Удирдах ажилтнууд болон инженер техникийн ажилтнуудад зориулан Лектор төвтэй хамтран

- “Ажлын байран дахь харилцааны бэрхшээлүүд ба түүнийг даван туулах нь”,
- “Үр дүнтэй харилцааны арга техникүүд”,
- “Манлайлалын суурь чадварууд”,
- “Ажилтнуудыг идэвхижүүлэх арга зүй” зэрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгуулсан.

Мөн Орон нутгийн олон сувгийн инженерүүдэд:

- Тоон телевизийн болон гэмтэл засварлах талаар,
- ХАБЭА сургалтуудыг зохион байгуулсан.

Тайлант хугацаанд Олон улсын хурал, зөвлөлгөөн, сургалтанд:

- АНУ-д 1 хүн,
- Германд 1 хүн,
- Малайзад 2 хүн,
- Францад 4 хүн тус тус хамрагдлаа.

1. Ахлах мэргэжилтэн Л.Туул 2014.03.09 - 2014.03.14-нд АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулагдсан SATELLITE 2014 үзэсгэлэнгийн ажиллагаанд оролцон мэдээ мэдээлэл, дүн шинжилгээ, харилцааны хамтын ажиллагааны томоохон наадам болсон хиймэл дагуулын холбооны үйлдвэрлэл үйлчилгээний 12000 гаруй байгууллагын танилцуулгыг үзэж сонирхон оролцож буй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоов.

2. ОСТАА-ны дарга Т.Төрмөнх, Мэргэжилтэн Д.Оюу нар 2014 оны 03 дугаар сар 04-07-ны хооронд Малайз улсын Куала-Лумпур хотод ABU /Азийн өргөн нэвтрүүлгийн холбоо/-с зохион байгуусан сургалт семинарт оролцож “ABU dijital broadcasting symposium-2014” сэдвийн дор embracing technological innovations чиглэлээр тус хотын “Istana” зочид буудалд зохион байгуулагдсан. Тоон системийн лекцүүд “Тоон телевиз”, “Тоон радио” гэсэн үндсэн 2 хэсэгт хуваагдаж тоон техникийн хөгжлийн чиг хандлага, дэлхийн улсуудад тоон технологи нэвтэрч буй өнөөгийн байдал, хөгжлийн ирээдүйн төлөв сэдвээр орон орны төлөөлөгчид илтгэл тавьж, илтгэлээс хэрэгтэй мэдээллээ бичиж, тэмдэглэл хөтөлж, монгол оронд тоон ТВ, тоон радио, бусад тоон систем нэвтрүүлэх ажилд үнэтэй туршлага хуримтлууллаа.

Мөн телевиз радиогийн тоон студи, бусад дагалдах салбаруудын амжилт ололтын



талаар өргөн сурталчилгаа танилцуулга явагдаж сурталчилгааны материал, флаш, cd авчирч ИТА-д тараасан.

3. Техникийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Ануужин, СБХ-ийн дарга Д.Ариун, ОСТАА-гийн инженер Д.Дамдин, Баян-Өлгий аймгийн РТС-ын дарга Н.Дидар нар 2014 оны 6-р сарын 23-ноос 7-р сарын 01-ны өдрүүдэд Франц улсын Thomson broadcast компанийн тоног төхөөрөмжийн тест болон сургалтанд " Монгол улсын телевизийн өргөн нэвтрүүлгийг анолог системээс тоон системд шилжүүлэх" төслийн гүйцэтгэгч IT zone компанийн зардлаар Франц улсад сургалтанд амжилттай хамрагдаад ирлээ. Үндэсний Аудитын газраас томилогдсон "Акпар Аудит" ХХК 2013 оны санхүүгийн тайланд явцын аудит хийж зөвлөмж өгсний дагуу Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолтой нийцүүлэн "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" боловсруулан мөрдөж ажиллаж байна.
4. Тоон тв станцын онол, ашиглалт үйлчилгээ сэдвээр Newtelcom-н гадаад инженер 1удаа, тоон сигналын оролтын headend зогсуурын төхөөрөмжүүдийн ажиллагаа, SFN сүлжээ сэдвээр хятад мэргэжилтэн 2удаа, шилэн кабелийн encoder, multiplexr сэдвээр инженер Баасанхүү 2 удаа ТТС-н ИТА-д сургалт явуулсан,
5. Цамхагийн өргүүрийн операторын сургалтанд 1 хүнийг хамруулж үнэмлэх олгуулсан. Өндөрт ажиллах ИТА-дад сургалт зохион байгуулсан. 8 хүн оролцсон, шалгалт авч зэргийг баталгаажуулна.
6. ХАБЭА-н давтан зааварчилгаа өгөгдөн, нийт ИТА нар шалгалт өгч зэргээ баталгаажуулсан ба шинээр зэрэг авах шаардлагатай 7 хүний асуудлыг техникийн зөвлөлд оруулж, зохих зэргийг олгосон.
7. Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан Тендерийн эрхийн сургалтанд 5 ажилтныг хамруулснаас хуулийн зөвлөх холбогдох эрхийн гэрчилгээг авсан.

***Гурав. "ИТШХХ-ны салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийсэн ажлын талаар:***

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийт эмэгтэйчүүдээ хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Тус байгууллагын харъяанд байдаг 86 өндөр настны судалгааг үндэслэн төсөв зохиож, батлагдсан төсвийн хүрээнд өндөр настнуудын сар шинийн хүлээн авалтыг **Төр засгийн Элит** төвд зохион байгуулан 60 орчим өндөр настан болон байгууллагын удирдлагууд, салбарын ахмадын нэгдсэн хорооны дарга Л.Дашцэрэн гуай нар оролцон баяр хүргэн үг хэлж зургаа авхуулан, арга хэмжээ амжилттай боллоо.

Мөн эдгээр ахмадууд сар шинийн гарын бэлэг болгон тус бүрт 20000 төгрөгийг тушаал төлөвлөн батлуулж, арга хэмжээн дээр ахмадуудад олгосон.

**МУ-д радио үүссэний 80 жилийн ойг тохиолдуулан радиогийн өдрөөр Хонхор**

дахь их хүчний Радио нэвтрүүлэх төв станцад ажиллаж байсан ахмад холбоочид болон Холбооны яамны үе үеийн сайд нарыг урин Хонхорын станцын үйл ажиллагаа болон одоо ажиллаж буй хамт олонтой танилцуулан санал сэтгэгдлийг нь сонсож хүндэтгэл үзүүллээ.

Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан байгууллагын нийт ахмадуудыг Их тэнгэр цогцолборт хүлээн авч хүндэтгэлийн зоог барьсан.

Тайлант хугацаанд МТШХХГ-аас батлагдсан “ МТШХХ-ны салбарын Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, энэ ажлын хүрээнд дараахи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Байгууллагын санхүүгийн байдлыг харгалзан ажиллагсдын цалинг дундчаар 15 хувиар нэмэгдүүллээ.

2. Байгууллага дээр хоолны газрыг шинээр бий болгож тохижилт, ажиллах нөхцөл, ариутгал цэвэрлэгээ, ажиллах боловсон хүчний асуудлыг шийдвэрлэлээ.

3 .Ажиллагсдын хоол унааны мөнгийг 2014 оны Хамтын гэрээгээр 500 төгрөгөөр нэмэгдүүлж 3500 төгрөг болгосон.

4 .Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хамтын гэрээний хэрэгжилтийн хүрээнд орон сууцны өргөдлийн дараалал, амьжиргааны түвшин, амьдарлын нөхцөл, ажлын үр дүн зэргийг харгалзан 5 инженер техникийн ажилтанд орон сууцны дэмжлэг тус бүр 5 сая төгрөг, 2 ажилтанд орон байрны нөхцөл сайжруулах тус бүр 2,5 сая төгрөгийг тус тус олголоо.

5. Гэр хороололд гэрт буюу галлагаатай байшинд амьдардаг ажиллагсад болон ахмадуудад 2 тонн нүүрсийг олгосон.

6 .Мөн ар гэрийн гачигдал тохиолдсон ажиллагсад болон ахмадуудад хамтын гэрээний дагуу тэтгэмжийг холбогдох материалыг үндэслэн тэтгэмж олголоо.

7. Тайлант хугацаанд Рашаан сувилалд сувилуулсан ажиллагсад хамтын гэрээний дагуу хөнгөлөлт олголоо.

8. Байгууллагын нийт ажиллагсдыг Хавдар судлалын үндэсний төв дээр Эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт хамруулсан.

9. Байгууллагын харьяалалд байдаг ахмадуудыг Нийслэлийн халамж үйлчилгээний газартай хамтран клиникийн нэгдсэн 1-р эмнэлэгт 7 төрлийн үзлэгт хамруулсан.

**Дөрөв . Ажиллагсдын ажиллах нөхцөл, ажлын байрны тохижилт, аж ахуй, хангамж үйлчилгээний талаар:**

Олон сувгийн телевизийн ашиглалтын албаны инженер техникийн ажиллагсдын ажлын байрыг шинээр тохижуулан вакуум хаалт хийлээ.

**2014 онд байгууллагын төв байрны ар талд технологийн автомашины зориулалтаар 5 машины дулаан грашийг шинээр бариуллаа.**

Байгууллагын урьд талын талбайг цементелж , фасадыг тохижуулж, төв хаалганы гадна талд давхар металл хаалга шинээр хийж, дээд талд нь саравч хийсэн.

Төв байрыг бүрэн камержуулсан.

Зуны цагт бөгчим ажлын өрөөнүүдэд халуун, хүйтэн 2 горимд ажиллах кондешин авч байрлуулсан.

Хонхор дахь РНТС-ын хашаандах складыг цэвэрлэсэн.

Өвлийн бэлтгэл ажлын хүрээнд Багануурын нүүрсний уурхайтай гэрээ хийж, 700 тонн нүүрсний таталтыг хийж өвлийн бэлтгэл ажлыг хангалаа.

Автомашинуудын өвлийн тос масло солих, шаардлагатай өвлийн дугуйг авч өгсөн.

Узелийн өрөөний халуун хүйтэн усны хаалтыг шинэчилсэн.

Цайны өрөөнд аяга таваг ариутгагч болон бусад сав, тоног төхөөрөмжийг авч хангалт хийлээ.

Байгууллагын төв байрны хаалганы дээр урсдаг зар, байгууллагын хаяг логог шинээр хийлгэсэн.

Байгууллагын дээвэр дээрхи хуучин хаягны үсгийг буулгаж, доторхи LED гэрлийг сольсон.

МХГ-ын шаардлагын дагуу ТТС-ын халаалтын оруулгын 4 ш вентиль бүхий узелийн хэсэгт хөнгөн цагаан ба лампиран хаалт хийлгэсэн

ТТС щитний өрөөний хана тааз, Техникийн 1-р давхарын заалны ханыг шаргал өнгийн тосон будгаар будаж өнгө үзэмжийг сайжруулсан.

ТТС-ын ээлжийн ИТА-ын цайны өрөөнд гал тогооны шүүгээ тумбочка хийж тавьсан

ТТС-ын хуучин гэрэлтүүлгийн системийг шинэчлэн нэмэх ба хасах хэлбэрийн гэрлүүдээр сольсон

Чингэлтэй сайтын байрны гадна хаалгыг “бүргэд” хаалгаар сольсон

Чингэлтэйн ‘ОО’-ийг шинээр ухаж, зориулалтын материалаар В.Батбаатар,Ц.Хадбат бусад ээлжийн ажилчдын хамтаар чанартай барьж дуусгасан

Өвлийн бэлтгэл ажлын хүрээнд Чингэлтэй станцад ээлжийн өвлийн хэрэгцээний 1тн ундны ус, 40л дизель түлш, 5л тос гарган нөөцөлж, байр цонхнуудыг дулаалж, 380в тоолуурыг халаалтын тенд суурилуулсан.

РНТС-ын ТЗ-1-ээс ТЗ-2, ТЗ-3 хүртлэх галларей / переход / -н дээврийг засварласан. Хонхорын станцын гадна фасадыг будаж байгууллагын гадаад өнгө үзэмжийг сайжруулсан.

РНТС-ын ТЗ-1 ийн дээврийг 3 үе буулгаж дээврийн их засварын ажлыг гаднын байгууллагаар гүйцэтгүүлсэн.

РНТС-ын Харуулын байрнаас станцын байр хүртлэх автозамын шөнийн гэрэлтүүлгийг ажилд оруулж, хугацааны улирдлагатай болгосон.

РНТС-ын Харуулын байрнаас станцын байр хүртлэх автозамыг нөхөөс хийж сайжруулсан.

РНТС-ын Харуулын байранд их засвар хийж ажилтны ажлын байрны нөхцлийг сайжруулсан.

Антеннаас буусан модыг ашиглан авс хадгалах хашаа барьж 10 тонн хадлан авч нөөцөлсөн.

**Ажиллагсдын хэрэгцээнд зориулан 2 жилийн дараа ургац авахаар төлөвлөж 0,52 га газар 500 ширхэг чацаргана , үхрийн нүдний суулгац суулгасан. Өтөг модны үртэс,**

бордоо зэргийг бэлдэж ашигласан. **3 тонн мод** усалгааны чайна суурилуулсан. Суулгацын талбайд **324 м** хамгаалалтын хашаа барьж будаж өнгө үзэмжийг нь сайжруулсан.

**Тав. Ажиллагсдыг шагнаж урамшуулсан талаар:**

МУ-д Орчин цагийн харилцаа холбоо үүсч хөгжсний 93 жилийн ой, Цахилгаан холбоо мэдээлэлжсэн нийгмийн дэлхийн өдрийг тохиолдуулан холбогдох дээд шатны байгууллагад уламжлан тэргүүний ажилтан, ажиллагсдыг Төрийн , салбарын, байгууллагын шагналаар урамшуулан шагналаа. Үүнд:

Төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор Радио нэвтрүүлэх төв станцын дарга О.Ганхуяг шагнагдсан, мөн РНТС-ын инженер Н.Намсрайжав, ээлжийн инженер Х.Пүрэвсүрэн, хөргөлтийн техникч Б.Ганбаатар, ээлжийн ахлагч инженер Х.Алтанцэцэг, Өмнөговийн РТС-ын ээлжийн техникч Ч.Энхбат, Баян-Өлгий РТС-ын ээлжийн ахлах техникч Х.Дулат нар Мэдээлэл харилцаа холбооны салбарын Тэргүүний ажилтан цол тэмдгээр, Баян-Өлгийн аймгийн ахлах инженер Р.Сайран, Хэнтий аймгийн олон сувгийн засварын инженер Т.Бат-Эрдэнэ, ХШРА-ны инженер Д.Хатанбүүвэй, ШУА-ны ээлжийн инженер Д.Бямбасүрэн РНТС-ын үйлчлэгч П.Төрбат, ТТС-ын үйлчлэгч П.Алтанзаяа нар МТШХХГ-ын Хүндэт жуух бичгээр, нэр бүхий 11 ажилтан байгууллагын мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

Мөн дээрхи баярыг тохиолдуулан 8 ажилтан шинээр МУ-ын Хүндэт холбоочин үнэмлэх тэмдгээр шагнагдлаа.

2014 онд Радиогийн 80 жил тохиож буйтай холбогдуулан Мэдээлэл харилцаа холбоо ба холбоочин түүх судлалын төвөөс зохион байгуулсан “ Радио монголд-80 жил” хэвлэлийн бага хуралд байгууллагаас 20 ажилтан албан хаагчдыг зохион байгуулалттай оролцуулж, техникийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Туул, ТТС-ын инженер Б.Оюунбат нар уг хуралд илтгэл тавьлаа

**Зургаа . Эрх зүйн хяналтын талаар**

**1. Гэрээ хэлэлцээрийн хугацаа сунгалт:**

ТМ телевиз, Eagle телевиз, MN25 суваг телевиз /түрээсийн гэрээ болон дахин дамжуулах гэрээ/, UBS телевиз /дахин дамжуулах гэрээ/ ,SBN телевиз, Эх орон телевиз, Сансар дижитал ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК, ДДЭШ телевиз ХХК, ЭН БИ СИ ХХК, УБЦТС ХК, УБТЗ (Түнхэл сайтын цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ), Тусгай дугаарын гэрээ (18006), Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ зэрэг байгууллагын гэрээнүүдийг шинэчлэгдсэн тарифаар тооцож шинээр гэрээ байгуулсан. Түрээсийн гэрээний орлого сард 2 163 425 төгрөгөөр нэмэгдсэн.

**2. Байгууллагын удирдлагаас шаардлагатай гэж үзсэн асуудлаар хувь хүн болон хуулийн этгээдтэй шинээр байгуулсан гэрээнүүдийн хяналт :**

Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Аржанчивлан болон Өвөржанчивлан амралтын газар, Юнител /Хөвсгөл, Баян-өлгий, Өвөрхангай, Шархад /, Мобиком / баян-Өлгий, булган аймаг/, Скайтел ХХК /Увс аймаг/, Бозу ХХК /булган аймаг/, Тариатын эхэн ХХК /Булган аймаг/, ДДЭШ ХХК /олон сувгийн сайтад түрээсийн гэрээ/ зэрэг байгууллагатай шинээр гэрээ байгуулсан бөгөөд орлого сард 3 730 000 төгрөгөөр нэмэгдсэн.

Онч сөрвэй ХХК, автомашин худалдан авах гэрээ /Ланд 200, Ниссан навара, сонато , Subaru forestor/, худалдах гэрээ /мэргэдийн гал ХХК ,ITMG /, Мөнхтулга-Уянга ХХК, АМЭ трейд ХХК, Багануур МХС /оператор ажиллагааны гэрээ/, Налайх /оператор ажиллагааны гэрээ/, Жүгдэр /Оператор ажиллагааны гэрээ/ Б.Ганхуяг /хонхорын ЗОН татах/, Ш.Эрдэнээ / грашад сан тавих, сагс хийх/, Ш.Начинцогт /Хонхорын бохирын ус соруулах/, “Алсын хүч” ХХК /олон сувгийн станц барих ажил/ зэрэг хувь хүн болон хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнүүдийг хянаж ажиллалаа.

### **3. Харьяалах дээд шатны байгууллага болон Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын талаар:**

- “Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай журам”,
- “Байгууллагын нууцыг хамгаалах тухай журам”-ыг тус тус шинээр боловсруулсан,
- “Хөдөлмөрийн дотоод журам”,
- “Радио телевизийн дамжуулах сүлжээний техник технологийн горимд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”,
- “Радио телевизийн дамжуулах сүлжээний техник технологийн горимд хяналт, шалгалт хийх аргачлал ”,
- “Технологийн ажил хариуцсан албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлага”,
- “Дотоод албан томилолтын журам”,
- “Гадаад томилолтын журам”,
- “Олон сувгийн телевизийн сүлжээг технологийн удирдлага хангах журам”-уудад нэмэлт өөрчлөлт оруулсан.

- “Эрх зүйн шинэчлэл 2014” –ийн хүрээнд Харилцаа холбооны тухай хуулийн болон Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, холбогдох хурлуудад сууж ажиллаж, Ажлын хэсгээс Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн “үзэл баримтлалыг” батлуулахаар Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

- Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу байгууллагын хүрээнд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа-ны төлөвлөгөөг” боловсруулан Газрын даргын 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1 тоот тушаалаар батлуулан уг төлөвлөгөөний дагуу холбогдох хэлтэс, албадуудтай хамтран зохих сургалт, нэмэлт ажлуудыг хийж, хагас бүтэн жилээр тайлагнаж цахим хуудаст байршуулсан.

Захиргааны байр болон Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Налайх дүүргийн нутаг дэвсгэр дэх олон сувгийн телевизийн сайтын нийт 8 газрын газар эзэмших гэрчилгээг Эрхийн Улсын бүртгэлд бүртгүүлээ.

Хонхорын станцын газар эзэмших гэрчилгээг газрын албанаас авсан.

### **3. Гэрээ хэлэлцээрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан талаар:**

“УБЦТС” ХК-тай Хонхорын станцын маргаанд шүүхэд байгууллагыг төлөөлж оролцож байгаа бөгөөд өөрийн нэхэмжлэлийн үндэслэлд хууль зүйн гаргалгаа, хариуцагчийн сөрөг нэхэмжлэлд хариу тайлбар бичиж хүргүүлсэн.

“Шинжээч” томилуулах хүсэлтийг өгч “Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар”-аас Г.Отгонсүрэн байцаагчийг шинжээчээр томилуулсан, холбогдох бусад шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

“Протон” , “Гэрэлтүүлэг чимэглэл” ХХК, “Тэнгэрийн ауруг”, “Дижитал сити” ХХК, “Юнивишн”, “Мандал Женерал даатгал” ХХК зэрэг байгууллагатай хийсэн гэрээнүүдийг хянаж ажилласан.

### **Долоо . Санхүү, хөрөнгө оруулалтын талаар**

Байгууллагын 2014 онд актлах хөрөнгийн жагсаалтыг гарган холбогдох баримтуудыг бүрдүүлж ТӨХорооноос зөвшөөрөл авахаар хүргүүлсэний дагуу 496 488 557 төгрөгийн техник тоног төхөөрөмж актлах, 67 887 250 төгрөгийн автомашиныг дуудлага худалдаагаар зарж борлуулах зөвшөөрөл олгосныг хэрэгжүүлэн ажиллаа.

Тайлант хугацаанд 2012-2014 онуудад хэрэгжиж буй “ Монгол Улсын Телевизийн өргөн нэвтрүүлгийг аналог системээс тоон системд үе шаттай шилжүүлэх” төслийн гүйцэтгэгч ДДИШ компанийн 2013 онд суурилуулсан 86 тоон станцын 3,2 тэрбум , 2014 онд суурилуулсан 134 тоон телевизийн станцын 6.2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооны 2014 оны 06 сарын 19-ны 3/1763 дугаар албан бичиг, МТШХХГ-ын 2014 оны 9-р сарын 16-ны өдрийн 1/139 дугаар албан бичгийн дагуу бүртгэж авсан.

**МТШХХГ-ын Бүх нийтийн үүргийн сангийн хөрөнгөөр 11 аймгийн 18 суманд баригдсан цамхагийн 748 023 755 төгрөгийн хөрөнгийг мөн үндсэн хөрөнгөнд бүртгэж авлаа.** Харьяа дүүргийн НД, татварын хэлтэстэй зохих журмын дагуу цаг хугацаанд нь тооцоо хийж тайлангаа өгч байсан бөгөөд ажиллагсадын НДД, ЭМД-ын шимтгэлийн бичилтийг хийж баталгаажуулан ажиллаж байна.

Байгууллагын 2011, 2012, 2013 оны санхүүгийн тайлан, орлого зардлын эдийн засгийн үзүүлэлтүүдээр тайлан бэлтгэж Ажлын зөвлөлийн хуралд тайлагнасан.

Харилцагч байгууллагуудын гэрээний дагуу 2014 оны 12-р сарын 15-ны байдлаар **492,5 сая** төгрөгийн нэвтрүүлэг дамжуулсан орлого, **329,3 сая** төгрөгийн гэрээний

орлого, 150,9 сая төгрөгийн радиогийн орлого, **369,6 сая** төгрөгийн гадаад нэвтрүүлгийн орлого, **17,1 сая** төгрөгийн орчуулгын орлого тус тус орсон байна.

ТӨХ-ны 2014-2-13-ны өдрийн 90 дугаар тогтоолоор МЦХ ХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан **17 аймгийн 64,2 сая** төгрөгийн анхны өртөгтэй 62,1 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 105,5 мгц-ын давтамж дээр ажилладаг FM станцуудыг балансаас балансад шилжүүлэн авсан. 2014 оны Акпар аудитын гүйцэтгэлийн шалгалтаар Зөрчилгүй дүгнэлттэй, Мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтаар “Эрсдэлгүй байгуулага” үнэлгээтэй ажиллалаа.

Силвер синдикат аудитын 2014 оны явцын шалгалтаас өгсөн 18 зөвлөмжийн дагуу Хэлтэс, алба, станцуудад Захиргаа удирдлагын хэлтэстэй хамтран зөвлөмж боловсруулан хүргүүлээ.

**Найм. МУ-ын Засгийн газраас 2012-2014 онуудад хэрэгжиж буй “ Монгол Улсын Телевизийн өргөн нэвтрүүлгийг аналого системээс тоон системд үе шаттай шилжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийсэн ажлууд**

МУ-ын ЗГ-аас 2012-2014 онуудад хэрэгжиж буй “ Монгол Улсын Телевизийн өргөн нэвтрүүлгийг аналого системээс тоон системд үе шаттай шилжүүлэх” төслийн гүйцэтгэгч “IT ZONE” ХХК -ийн гүйцэтгэж буй төслийн хүрээнд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн 7 сум, Говь-Алтай, Ховд, Увс, Хөвсгөл, Баян-Өлгий аймгийн бүх сумдад, нийт 141 сумд DVB T2 стандартын THOMSON компанийн тоон ТВ төхөөрөмжийн суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

**1. Хөвсгөл аймаг**

Хөвсгөл аймгийн нийт 23 сум, Мөрөн хотод DVB T2 стандартын THOMSON компанийн тоон ТВ төхөөрөмжийн суурилуулалтын ажлыг нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй 2014 оны 07 -р сарын 19-ны өдрөөс 2014 оны 08 –р сарын 11-ны өдрийг дуустал хугацаанд өгөгдсөн техникийн нөхцөл шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн.

IT ZONE ХХК-ийн инженер техникийн ажилтануудын хамт нэвтрүүлэгчийн чадал, бусад үзүүлэлтүүдийг шалгах, IRD хүлээн авагчуудын өгөгдлүүдийг тохируулах, зогсуурын 220 В-ын тэжээлийн холболтыг хийж шалгасан ажлын дараа антенн фидерийн зохицуулалтыг шалгах, баглаа хайрцагт эргүүлэн хийж, тээвэрлэх автомашинд ачаалах зэрэг суурилуулалтын бэлтгэл ажлыг IT ZONE ХХК-ийн ажлын байранд хийж гүйцэтгэсэн.

